



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОР Д.ЗАГДЖАВ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Ж.Баян Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-18  
E-mail: [statelibrary@parliament.mn](mailto:statelibrary@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2024.09.25 № 14

Гадаадын зээл, тусламжийн эх  
үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр,  
арга хэмжээнд аудит хийсэн талаар

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.дэх хэсэгт "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх 5 зарчмыг баримтална", мөн хуулийн 14 дүгээр зүйлийн хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн тайлан бүхий хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж тус тус заасан.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн Аудитын тайлан, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн Аудитын тайланг УИХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцэн баталсан. Дүгнэлтэд дээрх болон бусад холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн нөхцөл байдал олноор тусгагдсанаас дараахыг үүгээр онцолж байна:

Гадаад зээл, буцалтгүй тусламжаар санхүүжсэн 10 төсөл хөтөлбөрийн бусад эргэлтийн хөрөнгө, дуусаагүй барилга байгууламж, урьдчилж гарсан зардал дансан 1 бүртгэлтэй нийт 534.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг эзэмшигч, ашиглагч байгууллага 1 шилжүүлж, төслийн хаалтыг хийж, санхүүгийн тайлан бэлтгээгүй зөрчил;

Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжилтийн 26.8 хувийг тусламжаар, 73.2 хувийг зээлээр санхүүжүүлсэн бөгөөд төсвийг ерөнхийлөн захирагч нар хүрсэн үр дүн, түүний танилцуулгыг бэлтгэж сангийн яаманд ирүүлээгүй зөрчил.

Эдгээр нь Монгол Улсын олон улс дахь нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйгээс гадна олон улсын байгууллагын тайлангаар Ардчиллын үзүүлэлтийг ухраахад нөлөөлдөг гол хүчин зүйлсийн нэг гэж тооцогддог. Түүнчлэн, төсвийн зарчмыг хэрэгжүүлэхдээ, тухайлбал, татвар төлөгчдийн мөнгө, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг төлөвлөх, зарцуулахдаа хууль тогтоомжийг зөрчдөг

07740036

албан тушаалтнууд зохих хариуцлага хүлээдэг эсэх тухай мэдээлэл олон нийтэд ил тод бус байна.

Иймд дээрх хууль тогтоомжийг зөрчсөн албан тушаалтнуудын талаар мэдээлэл авах, мөн гэмт хэрэг үйлдэж, зөрчил гаргасан байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох хуулийн хэрэгжилтийг дүгнэх, улмаар холбогдох хууль тогтоомжид шаардлагатай өөрчлөлтийг оруулах зорилгоор Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

Дээрх төслүүдтэй холбоотой зөрчлүүдийн талаарх дэлгэрэнгүй болон ижил зөрчил гаргасан холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч, албан тушаалтнуудын мэдээллийг 2020 оноос хойш он тус бүрээр;

Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2, 42.3, 42.4-т заасан зөрчлүүдийн талаар болон тэдгээрт хариуцлага тооцож, шийтгэл ногдуулсан тухай дэлгэрэнгүй мэдээллийг 2020 оноос хойш он тус бүрээр;

Прокурорын байгууллагад мэдэгдсэн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдлын талаар болон тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 2020 оноос хойш он тус бүрээр.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хэсэгт заасны дагуу холбогдох Байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ж.БАЯРМАА